



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 02 дугаар сарын 13
№07 (1255)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠯᠠᠭ ᠠᠯᠪᠠᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|-----|
| 137. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 655 |
| 138. | Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 657 |
| 139. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 658 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 140. | Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай | Дугаар 08 | 668 |
| 141. | Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 09 | 674 |
| 142. | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 10 | 675 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 143. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 234 | 676 |
| 144. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 235 | 676 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“6.4. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрхээ Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шилжүүлж болно.”

2/32 дугаар зүйлийн 32.5, 32.6 дахь хэсэг:

“32.5. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас бусад төрийн өмчит хуулийн этгээдийн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газрын шийдвэрээр хөнгөлж, чөлөөлж болно.

32.6. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлж болно.”

2 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн “32.5, 32.6, 32.7” дахь хэсгийн дугаарыг “32.7, 32.8, 32.9” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10

Үсвэр 10. Үсвэр 10



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “хоёр” гэснийг “гурван” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Борлуулсан хууль

Борлуулсан хууль /2023 оны 01 сарын 20-ны өдөр/

Борлуулсан хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “хоёр” гэснийг “гурван” гэж өөрчилсүгэй.

Борлуулсан хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “хоёр” гэснийг “гурван” гэж өөрчилсүгэй.

Борлуулсан хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “хоёр” гэснийг “гурван” гэж өөрчилсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

“6.34.авто замын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.4, 14.5 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.35.автотээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.36.аялал жуулчлалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.37.байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 4, 5 дахь хэсэг, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.38.барилгын техникийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.7 дахь заалт, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.1, 12.4, 12.5, 12.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.39.боловсролын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.19, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх



хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

6.40.газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 8.1, 8.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.2, 12.3, 12.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.41.газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.42.геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйл, 5.15 дугаар зүйлийн 1.2, 1.4 дэх заалт, 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.43.мал үржлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.44.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, 6.15, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.5, 13.9 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.45.нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.17, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.46.соёлын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.12, 9.13, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;



6.47.соёлын өвийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.7, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.48.ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.1, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.49.усан замын тээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.50.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.22, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.1, 14.2, 14.3, 14.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.51.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.52.хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10.16, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.53.хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.15, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.54.хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 14, 15, 16 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25, 13.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;



6.55.хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.24, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.56.цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.57.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.58.эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11, 6.19 дүгээр зүйл, 6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6 дахь заалт, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20, 23, 26 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.3, 2.4, 2.5 дахь заалт, 3, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.7, 2.9 дэх заалт, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 16 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 6.12 дугаар зүйл, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1.1, 1.5 дахь заалт, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 6, 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 1.9, 6.1, 7.2 дахь заалт, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12.5 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;



6.60.эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.19, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.61.эрчим хүчний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 7.2 дахь заалт, 12.8, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын “6.1 дүгээр зүйлийн 27” гэсний дараа “, 28” гэж, “6.5 дугаар зүйлийн 10, 12,” гэсний дараа “13,” гэж, “6.17 дугаар зүйлийн” гэсний дараа “5,” гэж, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, мөн зүйлийн 6.12 дахь заалтын “7.5 дугаар зүйл,” гэсний дараа “7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл,” гэж, мөн зүйлийн 6.14 дэх заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “6.33” гэсний дараа, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6.31” гэсний дараа “, 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтын “10.19 дүгээр зүйл,” гэснийг, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6.10,” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Удирдлага, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, олон нийтийн хяналтын талаар:

а/нүүрсний тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаанд гарсан зөрчлүүдэд дүн шинжилгээ хийн, шалтгаан, нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авах, хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б/нүүрсний тээвэрлэлт, экспортын асуудлаарх Засгийн газрын шалгалтын ажлыг эрчимжүүлж, Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаатай уялдуулах, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл харилцан солилцох, нүүрсний тээвэрлэлт, экспортын хэвийн, тасралтгүй үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүйгээр шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах;

в/байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударгаар хүртээх, баялгийн ашиглалт, хуваарилалтын ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх, 1991 онд батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг судлан үзэж, саналаа Улсын Их Хуралд танилцуулах;

г/Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Монголбанк болон холбогдох төрийн байгууллагуудын нүүрсний тээвэрлэлт,



экспорт, үнийн талаар гаргаж байгаа статистик мэдээллийн зөрүүтэй байдлыг судлан үзэж, бодитой мэдээлэл гаргах чиглэлээр анхаарч ажиллах;

д/“Шинэ сэргэлт”-ийн бодлогод тусгагдсан “Боомтын сэргэлт”-ийн хүрээнд хилийн боомтуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, боомт дагасан суурьшлын бүсүүдийн дэд бүтэц, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх Боомтын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

е/Ерөнхий хяналтын сонсголын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, явц байдлыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тухай бүр танилцуулах.

2/Төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр:

а/“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж, 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

б/2021, 2022 онуудад 1072 ширхэг хувьцааны ногдол ашгаа авч чадаагүй иргэдэд хувьцааны ногдол ашгийг нөхөн олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.

3/Ард түмний мэдэх эрхийг хангах чиглэлээр:

а/нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой хяналт, шалгалтын ажлын үр дүн, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, хэрэгжилтийн явц байдал, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүр шуурхай мэдээлж байх;

б/нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой оффтейк гэрээнүүд, түүнийг нууцад хамааруулсан шийдвэр, ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүд, 2010 оноос хойших 1072 хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбарыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд ил тод болгох;



в/Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх;

г/“Эрдэнэс-Таван толгой” ХК-иас санхүүжүүлсэн оффтейк гэрээний хүрээнд хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төмөр замын бүтээн байгуулалтад хөндлөнгийн аудит оруулах, аудитын дүгнэлтэд үндэслэн санхүүжилтийг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх.

2.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг шалган тогтоох” үүрэг бүхий Хянан шалгах түр хороо үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, цуглуулсан нотлох баримтуудыг шинжлэн судлах сонсголыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо /Г.Ганболд/-нд даалгасугай.

3.Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа нийтийн эрх ашгийг хөндсөн ерөнхий хяналтын сонсголын зохион байгуулалт, үр нөлөөг сайжруулах чиглэлээр оролцогчдын хамрах хүрээ, эрх, үүргийг тодорхой болгох, сонсголд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг оролцуулах, сонсголын үр дүнг мэдээлэх, сонсголын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, холбогдох байгууллагад үүрэг даалгавар өгөх, биелэлтэд хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд танилцуулахыг холбогдох Байнгын хороонд даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Мөнхбат/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Бичлэгний үндсэн зарчмуудын талаар

МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ

Хүндэтгэл
№ 10

2023 он 06 сарын 06-ны өдөр

МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ

Бичлэгний үндсэн зарчмуудын талаар
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ МОНГОЛЫН ХАМГААГАХ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Бүрэлдэхүүн гишүүнээр сонгогдох

Хүндэтгэн заруулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр
Монгол Улсын Их Хурлын Тогтоол

Хүндэтгэн заруулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр
Монгол Улсын Их Хурлын Тогтоол

Бүрэлдэхүүн гишүүнээр сонгогдох
Хүндэтгэн заруулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр
Монгол Улсын Их Хурлын Тогтоол

Бүрэлдэхүүн гишүүнээр сонгогдох
Хүндэтгэн заруулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр
Монгол Улсын Их Хурлын Тогтоол

Бүрэлдэхүүн гишүүнээр сонгогдох
Хүндэтгэн заруулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр
Монгол Улсын Их Хурлын Тогтоол

Бүрэлдэхүүн гишүүнээр сонгогдох
Хүндэтгэн заруулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр
Монгол Улсын Их Хурлын Тогтоол



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠒᠐-ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠸᠠᠨ ᠲᠤᠭᠲᠣᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ
ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ 30-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ

ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ

ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ

ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ

ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ
ᠲᠤᠭᠲᠣᠭ ᠲᠤᠨ ᠒᠐᠒᠓ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠑-ᠶ᠋ᠢᠨ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 339 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Сүрэнгийн Цэрэнхандыг Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 235

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 328 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Нямдоржийн Адъяаг Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003